PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tomus V (I3) Fasc. I8

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН" ДАХЬ ГАЗАР УСНЫ ДЭВСГЭР НЭР

Ч.Догсүрэн

«Монголын нууц товчоо» бол монгол газар усны эртний нэрийн хосгүй дурсгалт бичиг мөн. Уул зохиол энэ хир бидний мэдэж байгаагаар монголын газар усны нэрийн тухайд монгол газар буй хамгийн эртний бичгийн дурсгал болох «Орхон Сэлэнгийн (чулууны) бичээс» /1/-ийн дараах нь юм. «Орхон Сэлэнгийн бичээс» манай тоолын YIII зууны үе буюу төв Ази дахъ феодалын ёсны түрүү үед, «Монголын нууц товчоо» XIII зууны үе (1240 он)-д тус тус хамаарна.

Дундад эртний монголын газар ус ямаршуу нэртэй байсныг мэдэж болохуйц арвин хэрэглэгдэхүүн «Монголын нууц товчоон»-д бий. Уул номд буй монголын газар усны 150 гаруй оноосон нэрийг эрдэмтэд нилээд нягтлан үзжээ /2/. Харин газар усны дэвсгэр нэр (географические термины)-ийн тухайд бүхэлд нь нарийвчлан үзсэн зүйл хараахан үгүй байна гэж хэлж болно.

Долоон зуун жилийн тэртээ монголын газар ус чухам ямар дэвсгэр нэртэй байгаа вэ, түүнээс ямар нь бидний үед уламжлан ирээ вэ,тэдгээр нь авиа болон утгын талаар хэрхэн хувьссан байна вэ гэдэг бол эрхбиш нягтлан үзүүштэй бөгөөд тэр нь зөвхөн газар усны нэрийн судлалын тухайд төдийгүй монгол хэлний түүхэн шинжлэлд ч учир холбогдол бүхий зүйл мөн билээ.

Бидний ажигласнаар «Монголын нууц товчоон»-д газар усны 60 гаруй дэвсгэр нэр байгаа бөгөөд энэ удаа тэдгээрийг гүймэгхэн авч үзье.

А. ГАЗРЫН ДЭВСГЭР НЭР

АМАСАР § 80, 86, 136, 162, 177, 185, 251

a. qoyinaca anu nekejü telētü-amasara güyicejü saca-beki taicu qoyar-i bariba (§I36)+

b. ... tunggon-amasar joriju jebe-yi cabciyal-iyar bolqaba. (а/ Төлөтү амсар, б/ Дүн гүан боомт - Ц.Д.) (§25I)

Энэ үг уулын ам, боомт сүв газрыг заасан нэр мөн байна. Төв ба дорнод халхын аман ярианд уулын амны адгийг одоо ч «амсар» /4/ гэж нэрлэж байгаа бөгөөд манай орчин үеийн утга зохиолын хэлэнд «амсар сүв (боомт) газрыг батлан суух» гэх зэргээр хэрэглэсээр байна. Монгол бичигт (amasar) хэмээн эртний нь дуудлагыг хадгалан бичиж буй.

+ «Монголын нууц товчоон»-ны зүйлийн дугаар

А'УЛА § 118, 147, 195, 196, 199, 208, 240, 247, 266, 276

a. jebe ügulerün a'ula de'erece bi qarbula'a (§I47)

b. ...qoyinqsi iquriju a'ula asan bayiba (§I95)

c. ...ündür a'ula-yin nemüre metü setkijü yabuqu büle'e bi (§208)

(а/ уулан дээрээс, б/ уул өөд, в/ өндөр уулын - Ц.Д.)

Манай одоогийн'уул'гэдэг үг мөн байна. Гагцхүү аман ярианд а,у хоёрын хорондох г гээгдэж, нэгдүгээр үеийн нь а арынхаа үеийн у авианд татагдан ижилсээд урт уу болсон байна. Монгол бичигт (a'ula) хэмээн эртний нь хэлбэрийг хэвээр хадгалан бичсээр буй.

БАШ § 158, 177

...ürünggü huru'u hülde'et kisil-bas na'ur-a güyicejü buyiruq-qan-ni tende muqutqaba (§I58)

(Кишилбаш нуур - Ц.Д.)

Түрэг хэлний'толгой'гэсэн үг ажээ. Уул үг одоо газар усны дэвсгэр нэрийнхээ утгыг алджээ. Зөвхөн «Акбаш» (Цагаан толгой) зэрэг газар усны оноосон нэрийн бүтцэд орж явна.

БОЛДАГ § 59, 88, 97, 136, 177, 211, 282

a. onan-nu deli'ün-boldaq-a büküi-tür ...cinggis-gahan torejü'üi (§59)

b. kelüren-ü ködö'e-aral-un dolo'an-bolda'ut-ta /+/ (I36)

(а/ Дэлүүн болдог, б/ Долоон болдог - Ц.Д.)

Энэ үг сувгаавтархан өндөрлөг ухаа, толгойг заасан нэр байжээ. Одоо хоёрдугаар үеийн нь а өмнөх үеийнхээ о авианд татагдан уруулжиж о (> (bolduγ) болсоноос өөр өөрчлөлтгүй, утга нь ч хэвээрээ байна.

ГУ(Н) § 26, 123, 179

a. cinō-yin qun-tur qorqaqsan görö'esün mariyaju qarbui ...(§26)

b. qun-nu göro'ësü quya inu niketele siqaju...(§I79)

(а/ гууд хорьсон, б/ гууны гөрөөсийг - Ц.Д.)

Манай одоогийн'гуу'/5/ (- жалга, суваг) мөн байж болох юм.(Гэвч энэ үгийг цаашид нарийвчлан нягтлаж үзвэл зохино.)

+ bolda'ut - болдогууд.

ДАБА'А § 56, 146, 199, 247, 251, 254

a. teberigü cinü daba'at olan dababa (§56)

b. basa ündür daba'a daban örgen müren ketülün...(§I99)

c. vujiu-yi abcu hünegen-daba'ar dabaju...(§247)

(а/ даваа, б/ өндөр даваа, в/ Үнэгэн даваа - Ц.Д.)

Манай одоогийн 'даваа' гэдэг үг мөн. Гагцхүү аман яриand (хоёр а-гийн дунд байсан г сугаран) шууд «даваа» гэж дууддаг болсон байна. Монгол бичигт эртний нь хэлбэрийг хадгалан (dabaɣa/n/) гэж бичиж буй.

ЖАБА § 79

"qaci un, temüge, temülün qurban-i jaba ja'ura dürüjü bulqaldun bükui-tür..." (§79)

(уулын завд - Ц.Д.)

Уулын завсар хоорондын гүн явцуу газрыг ийн нэрлэж байжээ. Одоо аман яриand 'зав' хэмээн дуудан буй авач монгол бичигт (jaba) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй. Утга нь хэвээрээ байна.

КЭ'ЭР § 56, 105, 109, 123, 128, 152, 161, 177, 179, 190, 193, 197, 250, 252, 257, 258, 277

a. ke'er-ün görü'esün-ü ke'eli inu niketele siqaju öksü (§I23)

b. sa'ari-ke'er-e bawuba je (§I77)

(а/ хээрийн гөрөөсийг, б/ саарь хээр - Ц.Д.)

Манай одоогийн 'тал' /6/ гэж нэрлэдэг уужим талбиун цаʻаан газрыг ийн нэрлэж байжээ. Энэ нэр «Арвайхээр» /7/, «Сулин хээр» зэрэг газрын нэрд уул утгаа хадгалан үлдсэн байна. Одоо бол айл нутаглазнаагүй зэлүүд хөдөө газрыг «хээр» гэдэг болжээ. Аман яриand «хоёр э-ийн дундах г гээгдэн) хээр хэмээн дууддаг болсон боловч монгол бичигт (keger-e) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй.

КИЖИ'АР § 90, 128, 205, 257, 264

a. ...aqta-tan naiman mori(t) tere yeke güri'en-ü kiji'ar-a ebesülen bayiju bükui-tür üjeba...(§90)

b. hindus-un kiji'ar irgen-i dauli'at olan teme'et olan serkes-i abu'at irejü'üi (§264)

(а/ захад, б/ Индусийн хязгаар - Ц.Д.)

Нутгийн зах сөжүүр газрыг ийн нэрлэж байжээ. Одоо «Ховдын хязгаар», «Дорнод хязгаар» гэх мэтээр уг үгийн утгыг хэвээр нь хадгалан хэрэглэсээр байна. Аман яриand ж нь з болсон бөгөөд монгол бичгээр уул дуудлагаа дагуулан (kijaɣar) гэж бичиж буй.

КӨДЭ'Э § 136, 269, 282

"kelüren-ü köde'e aral ... ja'ura ordas bawuju bükui-tür

biciju dawusba (§282)

(хөдөө арал - Ц.Д.)

Гол уснаас зайдуу, хээрийн ургамал бүхий эр хөрстэй газрыг ийн нэрлэж байжээ. Одоо ч утга нь хэвээрээ байна. Харин «хот», «хөдөө» гэдэг шинэ ухагдахуунуг тэмдэглэсэн салаа утга буй болжээ. Монгол бичигт (ködege) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй.

КӨТЭГЭР § 191

"cinggis-qahan aba bawu'at abjiqa kötëger-ece gödölju ornu'u-yin keltegei-qada bawuju... (§I9I)

(Абжаа хүдгэр - Ц.Д.)

Манай одоогийн 'гүдгэр' гэдэг үг мөн болов уу. Монголоор (güdüger) гэж бичдэг болжээ. 'Хотгор' гэдгийн эсрэг утга заасан хэвээр байна.

НИРУ'УН § 147, 177, 183, 259

"tede niru'un de'erece sumun irejü, minu jebelegü aman caqan qula-in aman niri'u inu ququ ken qarbula'a a'ula de'erece" (§I47)

(уулан /9/ дээрээс - Ц.Д.)

Уулын урт шил газрыг ийн нэрлэж байжээ. Одоо ч утга нь хэвээр байна. Аман яриand(хоёр у-ийн хоорондох г сугаран урт у болсоны дээр нэгдүгээр үеийн нь и хойт үеийнхээ урт уу-д татагдан уруулшиж у болсод) «нуруу» хэмээн дуудагдах болжээ. Монгол бичигт эртний нь хэлбэрийг хэвээр хадгалан (niruɣu/n/) хэмээн бичиж буй.

ӨЛКЭС § 194, 196

"...cerig-iyen jibsi'ercü ... altay-yin ölkes /IO/ gürtele noqai kerel kerejü yabuju bidanu aqtas tarqut bui

(§I94) (Алтайн өлгий - Ц.Д.)

Уулын энгэр, зөвөр газрыг ийн нэрлэж байжээ. Одоо ч монголчууд уулын энгэр, элэг газрыг «уулын өлөг (өлгий)»гэдэг.

СҮБЧИД § 115

"to'oril-qan ... qaca'uratu-sübcit, huliyatu-sübcit da'arin görü'en inu abala'at ...icubai (§II5)

(Хацуурт сүбчид, Улиат сүбчид - Ц.Д.)

Уулсын хоорондох уйтан урт ам (одоо Улаанбаатар хотоос зүүхэн тийш байгаа Гачууртын ам, Улиастайн ам хоёр) газрыг «сүбчи» /11/ гэдэг байжээ. Уул үгийг одоо аман яриа болон бичигт хэрэглэхээ бүр больжээ. Харин төв халхчууд «амсар сүв» газар хэмээн хэлэлцээр буйн «сүв» нь /12/ эртний «сүбчид» гэдэг нэрийн салтар буйзаа.

ТАГ § 144, 158, 177

"naiman-u buyiruq-qan altay-yin ebür uluq-taq /I3/ jorin qaqacan ködoljü'üi (I44)

(Улуг таг - Ц.Д.)

«Таг» гэдэг нь 'уул' гэсэн утга бүхий түрэг гаралтай үг юм. Түрэг хэлтнүүдийн /14/ уул усанд өгсөн нэрээс эртний монголчууд улируулан хэрэглэжээ. Уул үг орчин үеийн монгол хэлэнд газар усны дэвсгэр нэрийнхээ утгыг алдаад «Байтаг» (Баян уул), «Харлугтаг» (Цаст уул) гэх мэт оноосон нэрийн бүтцэд орж явна.

ТӨКҮМ § 8, 157, 177

"toqto'a-beki-yi barqujin-tökům jůk hüldejü...kö'üd-i inu irge selte dawuliju cinggis-qahan-a ya'u ber ese ökba" (I57)

(Баргужин төхөм - Ц.Д.)

Одоо монголчууд хужир мараа, нуур, цольд бүхий их бага хотгор цайдамдуу газрыг төхөм хэмээн нэрлэж байгаа нь X111 зууны үеийн монголчуудын нэрлэж байсантай таарч байна. Монголоор (tökům) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр байна.

ТЭРИ'ҮН § 1, 96, 98, 108, 151, 179, 193, 202

a. naiman-u qara'ul qangqar-un teri'ün-ece söni olan qal üjejü... (I93)
b. ...tendece gödö(l)jü onan-nu teri'ün...gürbesü ... (I08)

(а/ Ханхарханы эхэн, б/ Ононы эх - Ц.Д.)

Угтаа 'толгой', 'эх (усны)', 'манлай' гэсэн утгатай үг аж. Эртний монголчууд уулын орой, ноёлох үзүүр, усны эх газрыг ийн нэрлэж байжээ. Одоо ч монголчууд уулын ноён оргил, цойлдуу үзүүрийг «тэргүүн өндөр» хэмээн нэрлэсээр байгаа бөгөөд усны эхийг «түрүү» хэмээн нэрлэдэг газар ч байна. /15/

УНДУР § 12, 79, 166, 170, 173, 185

"jürcedei arqai qoyar-i algincila'ulju ... jeje'er ündür-ün jer-qabciqay-yin amasara bükŭi-tŭr bücibei" (§I85)

(Жэжээр өндөр - Ц.Д.)

Энэ нэрийг уул гэдэг үгтэй ойролцоо утгаар хэрэглэж байсан бололтой. Одоо ч уулыг «Баян өндөр», «Улаан өндөр» гэх мэтээр нэрлэдэг нь эртний монголчуудын тэр ухаарц хэвээрээ уламжлан байгаа хэрэг байна.

ХАБЧАЛ § 111, 150, 177

"qara'un-qabcal sirqu'uldaju ja'un gu'un qarcu yisügei qan-tur ire'esŭ..." (§I50)

(Хараун хавцал - Ц.Д.)

Уулын гүн, цухал, хавчуу амыг тийн нэрлэж байсан бололтой. Монголчууд тийм газрыг одоо ч «хавцал» хэмээн нэрлэсээр буй. Гагцхүү аман яриандц нь ч болжээ. Монгол бичигт (qabcal) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр буй.

ХАВЧИХАЙ § 129, 185, 201

a. cinggis qahan jamuqa-da tende gödölgekdejü onan-nu jerene-qabciqay-a qorbai (I29)
b. ene üge-i jöbsiyejü ... jer-qabciqay-yin amasar-a bükŭi-tŭr bücibei (§I85)

(а/ Зээрэн хавцал, б/ Нэр хавчих - Ц.Д)

Орчин үеийн монгол хэлэнд «хавцгай» гэдэг үг бий бөгөөд тэр нь: 1. Эгц элгэн их хад; 2. Хад ус хавчсан газар буюу уул хадны бэрх сархиаг, цухал хавцал газар /16/ гэсэн хоёр салаа утгатай байна. Иймэд эртний монгол хэлний «хавчигай» гэдэг үгийг проф. Ц.Дамдинсүрэн гуай «хавцал», «хавчил» гэх орчуулсан нь санамсаргүй хэрэг биш ажээ.

a) ...jerene-qabciqay-a qorbai (мургав)
b) ...qabciqay-yin amasara bücibei (бүслэн хаав)

хэмээснээс үзэхэд яавч нэгэн цухал, гүн, хавцуу газар мөн байна. Гэхдээ (хавцлыг бодвол) мад явцуу, хоёр талаас нь тэнгэр тулам ханан хад нахцсан хавчуу ангал газрыг л тийн нэрлэж байсан болов уу гэлтэй. Тийм газрыг жирийн хавцлаас ялгахын тулд одоо «хадан хавцал» /17/ гэх нэрлэж байна.

ХАДА § 78, 175, 179, 191, 192, 209

"tende cinggis-qahan qalqa-yin ornu'u-yin keltegei qada-da yasun-inu talbi'ulba (§I75)

(хад - Ц.Д.)

Ургаа, оорцог том чулуу ийн нэрлэж байсан байж таарна. Одоо ч энэ үгийн утга, дуудлага яг хэвээрээ байна.

ХОРГИЛ § 195

"tayan-qan ügülerün teyin bö'esu a'ula-yin horgil de'e-re qaruya ke'ejü'üi (§I95)

(уулын оргил - Ц.Д.)

Уулын ноёлох өндрийг ийн нэрлэж байжээ Одоо гагцхүү уул үгийн эхэнд байсан төвөнгийн дуугүй шүргэх h гийгүүлэгч гээгдэн (orgil) болсоноос бус утга нь хэвээрээ байна.

ХОРМАЙ § I95

"naqu-qun-nu ebür a'ula-yin qormai kijin bayiju'ui (§I95)

(уулын хормой - Ц.Д.)

Уулын бэлийн залгаа доод этгээдийг ийн нэрлэж байжээ. Одоо (хөрдугаар үеийн нь а эгшиг өмнөх үеийнхээ о-д татагдан уруулшаад) 'хормой' гэдэг болжээ. Монгол бичигт (qormai, qormai) хэмээн хоёр янз бичих буй.

ХОШИ'УН § 55, 88, 247, 248

a. ciledü qosi'un qucilis qariju tergen-dŭriyen irekŭi-lŭ'e (§55)

b. tere ö'gede möci'et ...beder-qosi'un-u ... bükü-tür jolqalduba (§88)
(а/ хушуут тойрч, б/ Бэдэр хушуу - Ц.Д.)

Ухаа, хамрын шувтрага үзүүрийг ийн нэрлэж байжээ. Одоо утга дуудлага нь хэвээрээ байна.

ЧӨЛ § 94, 188, 279

a. ...nekün-usun-a ülü oron ... cöl-tür oroju usurqa-run qulat hilu'atuju bayiqun-i ... (§188)

b. dei secen ja'ura kelüren-ü uraq-cöl-nu-daca qariba (§94)
(а/ цөл газар, б/ Ураг цөл - Ц.Д.)

Айл нутаглаагүй, хүн амьтангүй уудам зэлүүд газрыг 'цөл' гэдэг байжээ. Одоо ч утга дуудлага нь хэвээрээ байна. Гэхдээ аман яриандаа «хээр»газрыг «цөл газар» гэх ч бас буй.

ЭТҮГЭН § 113, 201, 245, 254, 255

a. körisütei etügen körbejü büle'e (§254)

b. üküjü gebte'esü ölük yasun minu ündür etügen-tür... (§201)(а/ хөрст дэлхий, б/ үржилт эх дэлхий - Ц.Д.)

Дэлхий, эх газар гэсэн утгатай үг ажээ. Ардын аман зохиол (тууль, ерөөл, магтаал, сан сацлын судар зэрэг)-д олонтаа гардаг. Энэ үг одоо аман болон бичгийн хэлэнд нэгэнт хэрэглэгдэхээ больжээ.

Б. УСНЫ ХОЛБОГДОЛТОЙ ДЭВСГЭР НЭР

АРАЛ § 24, 105, 115, 136, 269, 282

a. orqan, selengge qoyar-un talqun-aral-aca icürün...(§115)

b. kelüren-ü köde'e-aral-un Dolo'an-boldaq-a silgincek qoyar ja'ura ... (§282)

Одоо эргэн тойрон усаар хүрээлэгдсэн хуурай газрыг арал гэнэ. Эртний монголчууд ойролцоо газраас эх аваад хоёр тийш дугуйран урсаж явсаар алсдаа нийлдэг хоёр гол усны хоорондох их хуурай газрыг бас арал хэмээн нэрлэдэг байжээ. Жишээ нь: Хэрлэн гол, Цэнхэрийн гол хоёрын хоорондох уужим их газрыг "хөдөө арал" гэж нэрлэж байсан байна. Үүнээс нь хөөн бодвол нуур буюу голын салаа, татуурын хоорондох хэсэг хуурай газрыг мөн л арал гэж байсан байж таарна. (Гагцхүү чухам ямар тодотголтой байсныг хэлэхэд хэцүү юм). Тэгэхээр арал гэдэг үгийн утга, дуудлага одоо ч яг хэвээрээ байгаа ажээ.

БУЛАГ § 128, 141

a. jalama-yin ebur-e olegei-bulaq-a burun ... (§128)

b. a'ucu ba'atur-tan tayici'ut, edün qarin alqui-bula'-a ci'ulju ... (§141)
(а/ Өлгий булаг, б/ Алхуй булаг - Ц.Д.)

Газар дороос оргилон гардаг усыг ийн нэрлэж байжээ. Утга дуудлага нь одоо ч хэвээрээ байна.

БЭЛЧИР § 159, 161, 177

"naiman-u kökse'ü-sabraq baidaraq-belcir-e ceri'üd-iyen jasaju ..." (§177)
(Байдраг голын билчир - Ц.Д.)

Голын уулзар газрыг ингэж нэрлэж байжээ. Утга нь одоо хэвээрээ байна. Гагцхүү аман яриандаа уул үгийн нэгдүгээр үеийн нь э арынхаа үеийн и-д татагдан и болоод «билчир» хэмээн дуудагдах болжээ. Гэвч монгол бичгээр ᠪᠡᠯᠴᠢᠷ (belcir) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй.

ГОЛ § 118, 142

a. ...qol-tur siqan bawuya ... (§118)

b. ...manaqar qatqulduya ke'eju icuju qol-tur neyilen qonoba(I42)(а/ голд, б/ голд - Ц.Д.)

«Монголын нууц товчоон»-д«гол»гэдэг үг гурван удаа гарч байна. Гэхдээ манай одоогийн'гол' хэмээн нэрлэдэг Цэнхэрийн голыг «Сангүр горухан» гээд Халх голыг заагаар л'Халх' гэж нэрлээд байжээ. Гэтэл 'гол' гэдэг үг маань Жамухын "голд шахан бууя" гэх мэт үгэнд гурван удаа гарч байна. Эртний монголчууд гол гэж урсгал усыг нэрлэж байв уу, эсвэл хөндийн ёроол дагуух журам газрыг хэлж байв уу гэдгийг одоо ялгаж хэлэхэд нилээд төвөгтэй юм. Ямар боловч эртний монголчууд газар усандаа 'гол' гэдэг дэвсгэр нэр өгсөн байжээ. Уул нэр нь одоо мөрөнгөөс багавтар, горхиноос их урсгал усны дэвсгэр нэр болсон байна.

ДАЛАЙ § 199, 245, 253, 265

"düriyen gerü-dece tünggelik-qoroqan huru'u bölök irgen newüju irebe (§28)
(далай - Ц.Д.)

Зах хязгаар нь үл мэдэгдэх савгүй их усыг ийн нэрлэж байжээ. Одоо ч монголчууд таван тивийг хүрээлсэн савгүй их усыг далай хэмээн нэрлэж, монгол бичгээр ᠳᠠᠯᠠᠢ (dalai) гэж эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр байна.

МҮРЭН § 1, 24, 30, 32, 53, 54, 55, 56, 72, 74, 84, 88, 94, 96, 98,104, 105, 106, 109, 141, 142, 152, 177, 179. 182,198,199, 236, 238, 245, 253, 254, 255, 257, 258, 262,264,270

a. jamuqa-yin esergü inu morilaya ke'eldüjü kelüren-mü-ren huru'u morilarun ... (§142)

b. ... qurban müred-ün teri'ün ken-e ber bü bawulutqun ke'ejü ilebe (§179)
(а/ Хэрлэн мөрөн, б/ гурван мөрөн - Ц.Д.)

Урсгал их усыг ийн нэрлэж байжээ. Одоо утга дуудлага нь хэвээрээ, монголчууд далай тэнгэст цутгадаг элбэг уст голыг мөрөн хэмээн нэрлэж байна. Монгол бичгээр ᠮᠥᠷᠡᠨ (muren) гэж эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй.

НА'УР § 53, 89, 122, 136, 151, 158, 176, 177, 182, 195, 208

a. Qara-jirüken-ü kökö-na'ur nuntuqlaju aqui-tur tarba-qat kücügür alaju iden büle'e (§89)

b. ...tedüi ...baljuna-na'ur bawuba (§182)

(а/ Хөх нуур, б/ Балхун нуур - Ц.Д.)

Ихээхэн хэмжээний тогтмол усыг нийн нэрлэх байхээ. Одоо ч утга нь хэвээрээ байна. Гагцхүү аман ярианд а у хоёрын дундах г сугарч а нь арынхаа у авианд татагдан урууллын у болоод нууд 'нуур' хэмээн дууддаг болжээ. Монгол бичгээр (na ur) гэж эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр байна.

ТЭНГИС § 1, 199

"toqto'a-yin qudu, qal, cila'un teri'üten kö'üt ... ji-qasun bolju tenggis dalai-tür oro'asu ..." (§199)

(тэнгис - Ц.Д.)

Далайгаас бага, нуураас тоймгүй их хэмжээний тогтмол усыг нийн нэрлэх байсан байх таарна. Одоо ч утга нь хэвээр байна. Гагцхүү эцсийн үеийн нь и өмнөх үеийнхээ э-тэй нэилсэн "тэнгэс" хэмээн дууддаг нь болсон байна. Гэвч монгол бичгээр (tenggis) хэмээн бичих буй.

УСУ § 8,9, 56, 158, 177, 188, 194 195, 255

a. uyila(q)daqu cinu usut olan ketülbe (§56)

b. ...naiman-u gücügüd-un buyiruq qan-tur morilaju ... soqoq-usun-a bükü-tür ... gödölbe (§158)

(а/ ус, б/ Согог ус - Ц.Д.)

Одоо монголчууд урсгал хийгээд тогтмол ус, худгийг ерөнхийд нь ус хэмээн нэрлэдэг нь эртний уламжлалтай ажээ.

ХАРГИ § 81, 82

"...onan-nu tün dotora kebte'esü üjekdegü ke'eju usun-u qargi-tur kebtebe" (§81)

(усны харги - Ц.Д.)

Усны түргэн урсгалтай хэсгийг нийн нэрлэх байхээ. Одоо утга дууд-лага нь хэвээрээ байна.

ХУДУГ § 279, 281

a. ...usu ügei qajar-a qudu'ut eri'üljü qarqa'ulju...(§281)

b. ...cöl-un qudu'ut eri'üljü qasituqai ... (§279)

(а/ худаг, б/ худаг - Ц.Д.)

Газрыг эрин гаргасан усыг нийн нэрлэх байхээ. Одоо ч утга, дууд-лага нь хэвээрээ байна. Гагцхүү орчин үеийн монгол хэлэнд эцсийн

нь үеийн у эгнээг зохицох хуулийн дагуу а болон дуудагдах байна. Монгол бичгэт (quddu) хэмээн бичих буй.

ҮЗЭХ § 72, 147, 209

a. ce'el usun niduralu'a ceugen cilawun cewurelu'e(§72)

b. ...ce'el usun-i nitulun abai je ta (§209)

(а/ Цээлийн ус, б/ цээлийн ус - Ц.Д.)

Урсгал усны тогтуун, түүн цүнхэл усыг нийн нэрлэх байхээ. Утга, дуудлага нь одоо ч хэвээрээ байна. Гагцхүү хөөр э-нийн дундах г нь сугарах нууд «цээл» хэмээн дууддагдах болжээ. Монгол бичгээр (ce'el) хэмээн бичих буй.

ЭРТЭ § 75, 81, 107, 96, 98. 107, 177

a. ...eke onan-nu ergi de'ere sa'uju elgü'ür gegi ja-malduju ... (§75)

b. ...burgi-ergi-de nuntuqlan bawuju ... (§96)

(а/ Ононы эрэг, б/ Бүргэ эрэг - Ц.Д.)

Одоо монголчууд гол, мөрөн,нуур, тэнгэсийн хөвөө болон гуу, жал-га, уул,хадны өнгийн тогтсон ирмэг газрыг нийн нэрлэх байгаа нь эртний нь утгаас өвөрдсөн зүйл үгүй ажээ. Аман ярианд "эрэг" хэ-мээн дууддаг болсон авч монгол бичгээр (ergi) хэмээн би-чих буй.

В. ОЙ МОДНЫ ХОЛБОГДОЛТОЙ ДЭВСГЭР НЭР

ТҮН § 50, 81, 82, 96, 104, 115, 130, 136, 164, 177, 264

a. taicu-tan bolun Onan-u tün-tür qurimlaya ke'eldüjü qurimlarun (§130)

b. ...tendece irejü tu'ula-yin qara tün-ne qan ecige ü-nu yisügei qan-lu'a anda bolulcaju... (§177)

(а/ Ононы дүгүй, б/ Туул голын хар дүгүй - Ц.Д.)

Балар нарэнгэ модыг нийн нэрлэх байсан бололтой. Учир нь гэвэл «түн» гэдэг нь эртний түрэг хэлнээ «харанхуй» гэсэн утгатай үг бай-сан бегеед уул үг одоо ч монгол хэлний "түнэр харанхуй" зэрэг үгэнд хэршин янз байна. «Түн» гэдэг үг одоо монгол хэлнээ эртнийхээ (га-зар усны дэвсгэр нэрийн) утгаар хэрэглэгдэхээ болиод улиард монголын хөвчирхүү нутагт газар усны онооссон нэрийн цэнэтэй хэв нэг дайрал-дах болжээ. Харин баруун монголын зарим нутагт энэт цэгүү үргасан их дэрсийг "түнгэ" гэж нэрлэх байгаа нь эртний 'түн' гэдэг нэрийн салтар болов уу гэлтэй.

ХОЙ § 12, 56, 79, 101, 102, 105, 112, 144, 149, 155, 202, 207, 239,240,241

a. quduqa-beki hoi demecen siagis jerin hödöljü'üi(§144)

b. hoy-yin irgen-i daru'ulun qorci tümen nedetügei (§207)

(а/ ой модны хүсэн, б/ ойн иргэнийг - Ц.Д.)

НА'УР § 53, 89, 122, 136, 151, 158, 176, 177, 182, 195, 208

a. Qara-jirüken-ü kökö-na'ur nuntuqlaju aqui-tur tarba-qat kücügür alaju iden büle'e (§89)

b. ...tedüi ...baljuna-na'ur bawuba (§I82)

(а/ Хөх нуур, б/ Балхүн нуур - Ц.Д.)

Ихээхэн хэмхэзний тогтмол усыг ийн нэрлэх байхээ. Одоо ч утга нь хэвээрээ байна. Гагцхүү аман ярианд а у хоёрын дундах г сугарч а нь арынхаа у авианд татагдан урууллын у болоод нууд 'нуур' хэмээн дуудаг болхээ. Монгол бичгээр (na ur) гэх эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр байна.

ТЭНГИС § 1, 129

"toqto'a-yin qudu, qal, cila'un teri'üten kö'üt ... ji-qasun bolju tenggis dalai-tür oro'asu ..." (§I99)

(тэнгис - Ц.Д.)

Далайгаас бага, нуураас тоймгүй их хэмхэзний тогтмол усыг ийн нэрлэх байсан байх таарна. Одоо ч утга нь хэвээр байна. Гагцхүү эцсийн үеийн нь и өмнөх үеийнхээ э-тэй нэилсэн "тэнгэс" хэмээн дуудагдаг болсон байна. Гэвч монгол бичгээр (tenggis) хэмээн бичих буй.

УСУ § 8,9, 56, 158, 177, 188, 194 195, 255

a. uyila(q)daqu cinu usut olan ketülbe (§56)

b. ...naiman-u gücügüd-un buyiruq qan-tur morilaju ... soqoq-usun-a bükü-tür ... gödölbe (§I58)

(а/ ус, б/ Согог ус - Ц.Д.)

Одоо монголчууд урсгал хийгээд тогтмол ус, худгийг ерөнхийд нь ус хэмээн нэрлэдэг нь эртний уламжлалтай ахээ.

ХАРГИ § 81, 82

"...onan-nu tün dotora kebte'esü üjekdegü ke'ejü usun-u qargi-tur kebtebe" (§8I)

(усны харги - Ц.Д.)

Усны түргэн урсгалтай хэсгийг ийн нэрлэх байхээ. Одоо утга дуудлага нь хэвээрээ байна.

ХУДУГ § 279, 281

a. ...usu ügei qajar-a qudu'ut eri'üljü qarqa'ulju...(§28I)

b. ...cöl-un qudu'ut eri'üljü qasituqai ... (§279)

(а/ худаг, б/ худаг - Ц.Д.)

Газрыг эрин гаргасан усыг ийн нэрлэх байхээ. Одоо ч утга, дуудлага нь хэвээрээ байна. Гагцхүү орчин үеийн монгол хэлэнд эцсийн нь үеийн у эгиг зохицох хуулийн дагуу а болон дуудагдах байна. Монгол бичигт (quddu) хэмээн бичих буй.

ЧЭ'ЭЛ § 72, 147, 209

a. ce'el usun niduralu'a ceugen cilawun cewurelu'e(§72)

b. ...ce'el usun-i nitulun abai je ta (§209)

(а/ Цээлийн ус, б/ цээлийн ус - Ц.Д.)

Урсгал усны тогтуун, үүн цүнхэл усыг ийн нэрлэх байхээ. Утга, дуудлага нь одоо ч хэвээрээ байна. Гагцхүү хоёр э-ийн дундах г нь сугаран дуудах «цээл» хэмээн дуудагдах болхээ. Монгол бичгээр (ce'el) хэмээн бичих буй.

ЭРТЭ § 75, 81, 107, 96, 98. 107, 177

a. ...eke onen-nu ergi de'ere sa'uju elgü'ür geügi ja-salduju ... (§75)

b. ...burgi-ergi-de nuntuqlan bawuju ... (§96)

(а/ Онон эрэг, б/ Бүрги эрэг - Ц.Д.)

Одоо монголчууд гол, мөрөн,нуур, тэнгэсийн хөвөө болон гуу, жалга, уул,хадны өнгийн тогтсон ирмэг газрыг ийн нэрлэх байгаа нь эртний нь утгаас өөрдсөн зүйл үгүй ахээ. Аман ярианд "эрэг" хэмээн дуудаг болсон авч монгол бичгээр (ergi) хэмээн бичих буй.

В. ОЙ МОДНЫ ХОЛБОГДОЛТОЙ ДЭВСГЭР НЭР

ТҮН § 50, 81, 82, 96, 104, 115, 130, 136, 164, 177, 264

a. taicu-tan bolun Onan-u tün-tür qurimlaya ke'eldüjü qurimlarun (§I30)

b. ...tendece irejü tu'ula-yin qara tün-ne qan ecige mi-nu yisügei qan-lu'a anda bolulcaju... (§I77)

(а/ Онон дүгүй, б/ Туул голын хар дүгүй - Ц.Д.)

Балар цэцэг модыг ийн нэрлэх байсан бололтой. Учир нүн гэвэл түн гэдэг нь эртний түрэг хэлнээ «харанхуй» гэсэн утгатай үг байсан бегеед уул үг одоо ч монгол хэлний 'түнэр харанхуй" зэрэг үгэнд хэрэглэн яваа байна. «Түн» гэдэг үг одоо монгол хэлнээ эртнийхээ (газар усны дэвсгэр нэрийн) утгаар хэрэглэгдэхээ болиод үлэрд монголын хөвчирхүү нутагт газар усны онооссон нэрийн цэнхэр хаа нэг дайралдах болхээ. Харин баруун монголын зарим нутагт нягт цагүү ургасан их дэрсийг "түнгэ" гэх нэрлэх байгаа нь эртний 'түн' гэдэг нэрийн салтар болов уу гэлтэй.

ХОЙ § 12, 56, 79, 101, 102, 105, 112, 144, 149, 155, 202, 207, 239,240,241

a. quduqa-beki hoi demecen siregis jerin ködöljü'üi(§I44)

b. hoy-yin irgen-i daru'ulun qorci tümen medetügei (§207)

(а/ ой модны хүсэх, б/ ойн иргэнийг - Ц.Д.)

Уул, хөдөөд ургасан их модыг одоо ч 'ой' хэмээн нэрлэж буй нь эртнээс уламжлан ирсэн нэр аж. Гагцхүү уул үгийн эхэнд байсан төвөнгийн дуугүй шүргэх h авиа гээгдэн 'ой' хэмээн дуудагдах болсон бөгөөд одоо монгол бичгээр ᠣᠶᠠ (oi) хэмээн бичиж буй.

ХӨРҮҮ § 28, 115, 166, 170

a. düriyen gerü-daca tünggelik qoroqan huru'u bölök irgen newüjü ireba (§28)
b. mau-ündür-ün gerü-'er gödölürün ... (§170)

(а/ хяруудаас, б/ Мау өндрийн хярд гарч - Ц.Д.)

Уулын ар биед хүй хүйгээр ургасан ягц модыг монголчууд одоо 'хөрүү' /118/ хэмээн нэрлэдэг нь эртнээс уламжлан ирсэн нэрийн нэг байна. Монгол бичгээр ᠭᠡᠷᠡᠦ (kereu) хэмээн бичиж буй.

ШИГҮЙ § 79, 80, 102, 112

a. tergüne-ündür-ün siqui-dur sirquju orobasu tayici'-ut oron yadaju siqui-dur horcin sakiju (§79)
b. ... siqui hoi-tur sirkuju'u ... (§112)

(а/ шүгүй, б/ шүгүй - Ц.Д.)

Гол усны хөвөө дагаж ургасан шигүү их модыг эртний монголчууд ийн нэрлэж байсан бололтой. Одоо ч монголчуул гол усныа далар ургасан нягт их модыг «шүгүй» хэмээн нэрлэж байна. Аман яриандуул үгийн эхний үеийн и нь арынхаа үеийн у-д татагдан урудлиж у болоод 'шүгүй' хэмээн дуудагдах болсон боловч монгол бичгээр ᠰᠢᠤᠢ (si ui) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичсээр буй.

Г. ХӨТ СУУРИНЫ ХОЛБОГДОЛТОЙ ДЭВСГЭР НЭР

БАЛАГАСУН § 151, 247, 248, 249, 251, 252, 253, 257, 258, 259, 260, 261, 262, 263, 265, 267, 270, 272, 273, 274, 275, 276, 281

a. jebe dungcang balaqasun-i abcu qariju irejü ...(§248)
b. altan-qan... jüngdü-daca qarcu buru'udun namging-balaqasu oroju'ui (§251)

(а/ Дүн чан хот, б/ Нанжин хот - Ц.Д.)

Засаг захиргаа, гар урлал, худалдааны төв зангилгаа их хотыг эрт цагт голдуу'балагасун' хэмээн нэрлэж байсан бололтой юм. Улсын нийслэл хотыг 'хаан балагасун' гэж бичсэн нь дээр үеийн бичиг номд олонтаа үзэгддэг билээ. Одоо монголчууд дээр үеийн хотын эндэрхий үлдэцийг балгас хэмээн нэрлэдэг болжээ. Монгол бичгээр одоо ᠪᠠᠯᠠᠭᠠᠰᠤᠨ (bala asun) гэж, эртний нь хэлбэрийг хадгалан бичиж буй.

ХОТА § 248, 272

cinggis-qahan eye-tür anu oroju qotat qotat-tur ... ceri'üd-i qari'ulju icuba (§248)

(олон хотод - Ц.Д.)

Орны зах, хөдөө нутгийн томоохон төв газрыг ийн нэрлэж байсан бололтой. Гэхдээ «хота» нь «балагасун»-аасаа бага байжээ. Орчин үеийн монгол утга зохиолын хэлнээ «балгас» гэдэг нэр нь уг утгаараа хэрэглэгдэхээ болиод «хот» гэдэг нэр нь зонхилох болжээ. Монгол бичгээр ᠬᠣᠲᠠ (qota) хэмээн эртний нь хэлбэрийг хадгалан бичиж байна.

«Монголын нууц товчоон» дахь газар усны дэвсгэр нэрээс эдүгээ үед уламжлан ирсэн нь эдгээр бөгөөд тоотойхон хэдэн нэрийг эс тоолбол бараг цөмийн нь утга дуудлага хэвээрээ байна. Монголчууд бүр XIII зууны үед газар зүйн нарийн мэдлэгтэй, боловсорч хэвшсэн нэр томьёотой болсон байсны дээр өөрийн бичиг үсэгтэй, ном зохиолтой байж тэдгээр нь үеэс үед уламжлагдан ирсэн таатай нөхцол үүнд нөлөөлжээ.

Жич, одоо монгол хэлнээ огт хэрэглэгдэхээ больсоны дээр тэр тухайн үедээ чухам ямар утгатай байсан нь ч нэгэнт мэдэгдэхээ больсон, эрдэмтдийн тайлбар зөрүүтэй байгаа «дүрие(э)н», «жубур», «хубури» зэрэг хэдэн нэрийг цаашид нягт нарийн судлан үзэх шаардлагатай байна.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1 В.Я.Владимирцов Географические имена Орхонских надписей, сохранившиеся в монгольском. Докл. АН СССР, М., 1929

2 Х.Нэрлээ, Нуун товчоонд гардаг газар усны нэрийг хайж олсон нь. УБ., 1958; Ринчен, Бурхан халдун гэгч үгийн тайлбар, «Шинжлэх ухаан» сэтгүүл. 1946, Дугаар 8 г.м.

3 Акад. проф. Ц.Дамдинсүрэн гуай «Монголын нууц товчоо»-г хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлнээ хөрвүүлэн 1946 (монгол үсгээр), 1957 (кириллээр) онуудад тус тус хэвлүүлсэн билээ. Уул орчуулгат эхэвсэн нэрийг хаалтанд авав.

4 В.А.Казакевич, Современная монгольская топонимика, Л., 1934, 15-р талд.

5 Мөнай 'гуу' гэдэг үгийг угтаа хятадын гэдэг үгээс гаралтай гэж зарим эрдэмтэн үздэг.

6 «Монголын нууц товчоон»-ы уг эхэд 'тал' гэдэг үг байхгүй байна. Акад. Ц.Дамдинсүрэн гуай одоогийн монгол хэлээр орчуулахдаа унших ухаж мэдэхэд хялбар дөхөмийг бодон гагц нэг газар «хээр» гэдэг үгийг 'тал' (§ 67, 105), 'хөдөө' (§ 56) гэдэг үгээс орчуулсан буй.

7 Д.Базаргүр, «Газар зүйн домогт нэрийн тухай» , «Соёл утга зохиол» сонин, 1968, дугаар 48.

8 Аман хүзүү гэсэн үг.

9 Чингис "...niru'un de'erece ...ken qarbula'a" гээд "niru'u" -гаа тодотгосон эятай "a'ula de'erece" гэж эсуулгаа төгсгөсний дээр Зөв хариуд нь "a'ula de'erece bi qarbula'a" гэж үнэнээ өчдөг түүл Ц.Дамдинсүрэн гуай уул яриаин эсэнг барин "niru'un de'erece" гэдэг үгийг «уулан дээрээс» хэмээн орчуулсан байна.

10 Эрдэмтэн Х.Пэрлээ гуай Алтайн өвөөс эх авч ажсдаа нийлдэг гурван голын нэг - Өлгий хүйг нууц товчоонд гардаг «Алтайн өлгий» мөн гэдэг. (Х.Пэрлээ, «Монголын нууц товчоон»-ы газар усны нэрийн тухай урьдчилсан мэдээ», «Шинжлэх ухаан» сэтгүүл, 1948, дугаар 2-3.)

11 Х.Пэрлээ, Нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь, УБ., 1958.

12 Нууц товчооны 240 дүгээр зүйлд "mör, horum, sübes" гэдэг үг буй. Үүнээс үзвэл «сүв»гэдэг биеэ даасан нэр төр үед байсан бөгөөд үүл үг «нэвтрэх газар» гэсэн ерөнхий утгатай нэр байсан болой.

13 Улух (үлкен улхан) гэж эртний түрэгээр «их» гэсэн үг ажээ. Тэгэхээр Улух-таг гэдэг нь Их уул гэсэн үг бизээ.

14 Манай тооллын Y1-1X зууны үед түрэг, уйгар, хиргис зэрэг түрэг хэлт аймгууд одоогийн монгол нүтаг дээр эзлэн нөёрхөх байсан түүхтэй.

15 Эрдэнэт (Булганы) хотын өмнүүр зүүн тийшээ урсдаг Эрдэнэтийн голын эхийг нутгийн ардууд «Эрдэнэтийн түрүү» гэдэг.

16 Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он, 636-р талд үзнэ үү.

17 Ж.Дамдин. Анчны тэмдэглэл. УБ., 1975 он, 64-67-р талд Алтайн нэгэн хадан хавцлын тухай тодорхой өгүүлсэн буй. Жич, уул нь тийм газрыг «хадан хавчигай» буюу «хадан хавчил» гэж нэрлэх хэвтэй жирийн хавцлаас уйтан, давч цухал гэсэн санаа нь тод болж, хоорондынь ялгахад улам дөхөм болох асан.

18 Проф. Ц.Дамдинсүрэн гуайн "хяр" хэмээн орчуулсан тэр үгийг үг эхийн галигуудаас үзвэл gerü л гэсэн байна. «Монголын нууц товчоон»-ы эхийн галигт г, х баахан солиу явдаг нь үг эхэд г, х нилээд солигдсоны харгай ажээ. Иймээд уул gerü гэдэг үг манай одоогийн «хэрүү» гэдэг үг мөн нь маргаангүй.

ГАРЧИГ

Ширэндэв, Б.	Ленинская дружба монгольского и советского народов	5
Ширэндэв, Б.	Возрастание роли рабочего класса в жизни нашего социалистического общества	9
Ширэндэв, Б.	Главные задачи фундаментальных исследований Академии наук МНР на период 1976-1980 гг.	13
Майдар, Д.	К изучению истории и культуры кочевых народов Монголии	25
Бира, Ш.	The Dandin's "Kāvyādarśa" in Tibet and Mongolia	33
Лувсанвандан, Ш.	Үглэхүүний бүлгийн эцсийн үг нь үйл үгийн нэр заах, захирах хүсэх нөхцлөөр хэлбэржих тухай асуудалд	48
Лувсанвандан, Ш.	Хэлний онгон бүтэц, гүн бүтцийн тухай асуудалд	57
Дамдинсүрэн, Ц.	Несколько слов о Калачакре	63
Лувсанвандан, С.	К проблеме традиции и новаторства в монгольском изобразительном искусстве	70
Кошевой, К. К.	Интернациональная и национальная культура языка	82
Кошевая, И. Г. Гармаев, Л.И.	К типологии средств выражения видо-временных отношений (на материале форм длительности бурятского языка) в сопоставлении с русским и английским	86

Батуев, Д.	К изучению проблемы социально-экономической организации кочевого скотоводства как особого типа материального производства в северо-восточной Монголии и Халхе во II половине XIX нач. XX вв.	91
Маналжав, Л.	Об иноязычных заимствованиях в китайском языке	104
Сумъяабаатар, Б.	Арвангуравдугаар зууны үеийн нэгэн монгол цаазын бичиг	115
Ёндон, Д.	Орчуулагч Цэвэгийн Гэлэгжамц	135
Шагдарсурэн, Ц.	A propos de l'élevage des cinq espèces de bétail chez les Mongols	146
Бямбасан, П.	Монгол хэлний залгавар морфемийн англиллын асуудалд	170
Догсурэн, Ч.	"Монголын Нууц Товчоон" дахь газар усны дэвсгэр нэр	182

МОНГОЛЫН СУДЛАЛ

Эрхэнхий редактор Б.Ширэндэв
Ботийн редактор С.Лувсанвандан
Техник редактор хийж хуулж бичсэн
М.Хартолгойт.
В-70073 Хг.№ 209/78.ЗА.№ 262
Хэвлэлтэнд 1978 оны 8-р сард
Хэвлэгдсэн тоо 1300.Цаасны хэмжээ 70/108 1/16.Хэвлэлийн хуу - дас 12,5.Хэвлэлийн нэгж хуудас 17,5

Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв
Улаанбаатар. Нэгдсэн Үндэстний гудамж 19.

PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tomus V (13) Fasc. I—18

STUDIA MONGOLICA

ULAN-BATOR
1978

PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tomus V (I3) Fasc. I - I8

S T U D I A
M O N G O L I C A

ULAN-BATOR
I977

4M + 9M
M -695

Editorial Board: B.Shirendev,
Editor-in-Chief
Sh.Bira, assistant
of Editor-in-Chief

S.Luvsanvandan
Sh.Natsagdorj
Sh.Luvsanvandan
Ts.Damdinsuren

A.Luvsandendev
P.Luvsandorj
Ch.Jugder

YII -I
200-78